

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН
БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Д.Сарангэрэл

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох, барилгын салбарын үйлдвэрлэл, орон сууцны нийлүүлэлтийн хөрөнгө оруулалтыг дэмжих, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, санхүү, зах зээлийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгох, стратегийн хөрөнгө оруулалтыг татах замаар банк, санхүүгийн байгууллагуудын дунд өрсөлдөөнийг бий болгох, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөх, банкны орон сууцны зээл олгох эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг иргэдэд урт хугацаатай орон сууцны зээл олгоход зориулах, барилгын салбар болон хөрөнгийн зах зээлийг дэмжихэд чухал ач холбогдолтой гэж үзжээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн менежментийг сайжруулах, сангийн эрсдлийг зөв тооцох, иргэдийг орон сууцжуулах, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах талаар хууль санаачлагчаас асуулт асууж хариулт авлаа.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.БАТЦОГТ